


Энэхүү дасгал, даалгаврыг гүйцэтгэхдээ сурах бичгийн агуулгыг унших, теле хичээлээ давтан үзэх, судалж буй агуулгад холбогдох нэмэлт мэдээлэл, эх сурвалж судлах зэргээр мэдлэг, ойлголтоо бататгаарай.

Судлах бүлэг, дэд агуулга



- Дээрх 4 бүлэг сэдэв, 9 дэд агуулгын хүрээнд тулгуур ойлголт тайлбарлах, тохиолдол, эх сурвалж, мэдээлэлтэй ажиллах, жишээгээр тайлбарлах, дүн шинжилгээ хийх, үндэслэл, нотолгоо гаргах, шүүн тунгаах зэргээр мэдлэг, ойлголтоо бататган чадвар, хандлагаа хөгжүүлэх болно.
- Сурагч та илүү хариуцлагатай, цагийг зөв ашиглан ангийн найз нөхөд, багштайгаа хамтран ажиллах зэргээр бие даан бүтээлчээр суралцаарай.

	I	II	III
Түвшин	Блумын таксономийн танин мэдэхүйн үйл		
I	Сэргээн санах, ойлгох		
II	Хэрэглэх, задлан шинжлэх		
III	Үнэлэх, бүтээх		



## 1. БҮЛЭГ – Эрх зүй

### Бие даан суралцах үйлийн агуулга, төлөвлөлт

#### Хөтөч асуултууд:

1. Яагаад хүний эрх Үндсэн хуулийн суурь зарчим болдог вэ ?
2. Үндсэн хуульт ёс ба эрх зүйд захирагдах ёс хоорондоо ямар хамааралтай вэ ?
3. Өмчлөх эрхээ хэрхэн хэрэгжүүлж, хамгаалах вэ ?
4. Гэм хор, гэмт хэрэг ямар ялгаатай вэ?
5. Захиргаа иргэдийн хоорондын маргааныг хэрхэн шийдвэрлэх вэ?

#### Тулгуур ойлголтууд:

1. Үндсэн хууль
2. Үндсэн хуульт ёс, эрх зүйд захирагдах ёс
3. Өмч, оюуны өмч
4. Гэм хэрэг, гэм хор
5. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх

#### Agenda:

1. Сурах бичгээсээ уншиж, тэмдэглэл хөтлөх
2. Теле хичээл үзэх
3. Өмнөх мэдлэг ойлголтыг сэргээх
4. Цахим эх сурвалжаас найдвартай, албан ёсны сурвалж ашиглах
5. Дасгал даалгавраа ойлгож, алхамчлан гүйцэтгэх
  - Мэдлэг ойлголтын даалгавар
  - Чадвар хэрэглээний даалгавар
  - Хандлага, төлөвшлийн даалгавар
6. Өөрийн үнэлгээний хуудсаа тэмдэглэх
- 7 Хэрхэн сайжруулах төлөвлөгөө боловсруулах
- 8, Дэмжигч багшаас зөвлөгөө авах
9. Хичээл заадаг багшаас тусламж авах
- 10 Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хөтлөх

#### Даалгаврыг гүйцэтгэх зөвлөмж:

- Энэхүү ажлын хуудас нь сурагч таны өөрийн суралцахуйн хөтөч, ажлын дэвтэр тул эхлээд даалгаврын удирдамжийг анхааралтай бүрэн гүйцэд уншаарай
- Зөвлөмжийн дагуу гүйцэтгэх алхамуудыг сайтар баримтлан ажиллаарай.
- Тэмдэглэл бичих хэсэгт өөрийн санаа бодол, эргэцүүлэл, дүгнэлтээ бичихдээ аль болох үндэслэл, нотолгоотой бичээрэй.
- Тухайн даалгаврын хариултыг бичихдээ өгөгдсөн зайг баримтална гэдгийг анхаарна уу
- Сурах бичгийн дурьдсан хуудсыг заавал сайн уншиж, сонирхолтой олон янзын аргаар бүтээлч тэмдэглэл хөтөлж яваарай . Амжилт хүсье

**Даалгавар 1** Тулгуур ойлголтуудын мөн чанарыг тайлбарлах  
/ Сурах бичгийн 95-102, 72-75 -р талын мэдээллийг уншиж, даалгавраа хийгээрэй /  
<https://medle.mn/textbook/7?type=html>

**А. Доорхи тулгуур ойлголтуудыг тохирох тодорхойлолттой нь зөв холбож бичээрэй. / Доогуур нь зурсан түлхүүр үгийг сайн анхаарна уу /**

1. Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо
2. Хүний эрхийн зөрчил
3. Үндсэн хууль
4. Эрх зүйд захирагдах ёс

..... А.	.....Б	.....В	.....Г
Үндэсний хууль тогтоомж, олон улсын болон бүс нутгийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан <u>хүний эрхийг төр өөрийнхөө ямар нэгэн үйлдлээр зөрчсөн, эсхүл төрөөс хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн үүрэг биелэгдээгүй</u> байхыг хэлнэ.	<u>Хүний эрхийг баталгаажуулах</u> , улс орны суурь гол харилцааг зохицуулах үүрэгтэй, <u>хамгийн дээд хүчин чадалтай</u> , төрийн гол хууль юм.	МУ-ын Үндсэн хуульд зааснаар төр нь хүний эрхийн талаар <u>хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн</u> тулд тодорхой байгууллага, тогтолцоог бүрдүүлэн ажилладаг.	Шударга, тэгш, хүнлэг, энэрэнгүй байх, хүүхдийн эрх ашгийг зөрчихгүй байх гэх мэт <u>зарчмуудыг удирдлага болгон хууль тогтоомж, дүрэм, журамд захирагдах ёсыг</u> хэлнэ

**Б. Дээрх тулгуур ойлголтуудаас 2-ыг сонгон, тодорхой жишээ гаргаарай**

1.....

2.....

**В. Дээрхи тулгуур ойлголтуудын хоорондын хамаарлыг харуулсан бүдүүвч зураарай.**

**Г. Зурсан бүдүүвчийг ашиглан хүний эрхийг яагаад төр хамгаалдаг вэ, түүний шалтгааныг тайлбарлан бичээрэй**



.....

.....

.....

.....

Хүний эрх нь бүх хүний нэр төр, алдар хүндтэй хамт угаас заяагдсан төрөлх чанартай агаад нас, хүйс, арьсны өнгө, хэл, үндэс угсаа, язгуур, шашин, улс төрийн үзэл бодол үл харгалзан эрхээ бүгд тэгш эдлэх үндсэн зарчимд тулгуурладаг.



Дээрх QR кодоор нэвтэрч сурах бичгийн 93 талыг уншиж дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

## Даалгавар 2: Эх сурвалжид тулгуурлан төрийн хүлээх үүрэг тус бүрийг тайлбарлаж, жишээ гарган хүснэгтийг гүйцээж бөглөөрэй

### Эх сурвалж:

*“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”*

**Монгол улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг**

Хүндэтгэх	Хангах	Хамгаалах
Төрийн зүгээс хүмүүс эрхээ эдлэхэд ямар нэгэн саад болохгүй байх		
Жишээ нь: Эрүүдэн шүүх, хууль бусаар баривчлах	Жишээ:	Жишээ:

## Даалгавар 3: Асуултанд хариулаарай

1. Хүний эрхийн зөрчил гэж юуг вэ?
2. Хүний эрхийн зөрчлүүд гарахад гол нөлөөлдөг хүчин зүйл юу вэ?
3. Монгол улсад хүний эрхүүд яагаад зөрчигдөөд байна вэ?
4. Эрх зөрчигдсөн тохиолдолд хүний эрхийг хамгаалах ямар байгууллагуудад ханддаг вэ?

**Даалгавар 4.** Эх сурвалж ба тохиолдолд тулгуурлан өгөгдсөн асуултын дагуу задлан шинжлээрэй

### 1. Эх сурвалж:

*“...Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно...”*

**(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт)**

*“Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй.”*

**(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг)**

### 2. Тохиолдол:

..2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороонд байрлах орон сууцны байрны 00 өрөөг түрээслэгч, иргэн “Х”-ээс коронавируст халдвар илэрч, 11 дүгээр сарын 18-ны өдрийн 5 цагт Халдварт өвчин судлалын үндэсний төвд 10 настай хүүхдийн хамт тусгаарлагдсан. Түүний 4 ба 17 настай хоёр хүүхэд мөн өдөр “Улаанбаатар” зочид буудалд тусгаарлагдсан бөгөөд тэдэнд коронавируст халдвар илрээгүй тул 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 9 цагийн орчимд тусгаарлалтаас гарч, гэртээ ирсэн. Хүүхдүүдийг ирэхэд байранд нь хөл хорио тогтоосон, гэрт нь оруулахгүй байсан тул байрны ойролцоох цагдаагийн байранд түр хоргодон, Халдварт өвчин судлалын үндэсний төвд эмчлүүлж байсан ээждээ энэ тухай хэлсэн. Иргэн “Х” хүүхдүүдээ гэрт нь оруулахад туслахыг байрны “Сууц өмчлөгчдийн холбоо”-ны дарга “Д”-ээс хүсэхэд “танай орцны 16 хүн халдвар авсан учраас оршин суугчид тэднийг гэрт нь оруулахаас дургүйцсэн, байранд хөл хорио тогтоосон” гэжээ.

(Хүний эрхийн Үндэсний Комиссын дүн шинжилгээний илтгэх хуудсаас)

Асуулт:

1. Тохиолдолд хүний ямар эрх зөрчигдөж байна вэ?
2. Энэ зөрчил яагаад гарсан бэ, ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ ?
3. Зөрчигдсэн эрхээ хамгаалахын тулд юу хийх ёстой вэ?
4. Энэхүү эрхийг төрөөс хэрхэн хамгаалах үүрэгтэй вэ?
5. Эрх зөрчигдсэн тохиолдолд өөртөө болон бусдад хэрхэн туслах вэ? Арга хэлбэрийг тодорхойлж бичээрэй

**Даалгавар 5.** Төр хүн эрхээ эдлэх боломж, нөхцлийг бүрдүүлэх үүрэг хүлээх нь зайлшгүй юм. Үүнийг дараах бүдүүвчээр харуулсан байна. 01-04 дугаарын дагуу шар сумын чиглэлээр зүй тогтлыг холбоог сайн уншиж, 04 –т байх гаргалгааг гаргаж, дүгнэж бичээрэй



**Даалгавар 6.** Хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын тогтолцооны онцлог, зарчмыг харьцуулан, ач холбогдлыг дүгнэж бичээрэй ?

**Хүний эрхийг хамгаалах үндэсний механизм**

- Төр
- Хүний эрхийн үндэсний комисс
- Хүний эрхийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллага

Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн тохиолдолд гомдол гаргагч эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн өдрөөс, эсхүл зөрчигдсэн гэдгийг мэдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор, Комисст гомдол гаргах эрхтэй.

**Хүний эрхийг хамгаалах олон улсын механизм**

НҮБ-ын тогтолцоо /Ерөнхий ассамблей, Олон улсын шүүх, Аюулгүйн зөвлөл, Эдийн засаг нийгмийн зөвлөл, НҮБ-ын нарийн бичгийн дарга нарийн газар, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, энхийг сахиулах хүчинүүд /

- Хүний эрхийн хороо
- Хүүхдийн эрхийг хамгаалах конвенци
- Нүб-ийн олон улсын шүүх



.....

.....

.....

.....

**Даалгавар 1** Эрх зүйн тулгуур ойлголтуудын мөн чанарыг тайлбарлах  
/ Сурах бичгийн 76-78 -р талын мэдээллийг уншиж, даалгавраа хийгээрэй /  
<https://medle.mn/textbook/7?type=html>

**А. Өмчийн эрх зүйн дараах тулгуур ойлголтуудыг агуулгатай нь зөв холбоорой.**  
Түлхүүр үгийг олж доогуур нь зураарай.

/ Цэгийн оронд тохирох үсгийг нөхөн бичнэ. /

А. Эзэмших эрх

В. Захиран зарцуулах эрх

С. Өмчийн эрх

Д. Өмчийн хэлбэр

Е. Ашиглах эрх

.....	1	Нийтийн, хувийн, холимог өмчүүд
.....	2	Хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ байлгаж арчлах хамгаалах
.....	3	Эд юмсыг болон эрхийг хуулийн дагуу ашиглаж, түүнээс ашиг хонжоо олох, эсвэл ашиглан хэрэглэх
.....	4	Эд юмсыг бусдад худалдах, өвлүүлэх, шилжүүлэх зэргээр өөрийн эрхийн хүрээнд бүрэн өмчлөх байдал
.....	5	Өмчлөгч өмчлөлийн зүйлээ хуулийн дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах, халдлагаас хамгаалах тухай цогц ойлголт

**Б. Дээрх тулгуур ойлголтуудаас 2-ыг сонгон, тодорхой жишээ гаргаарай**

1.....

2.....

**В. Дээрхи тулгуур ойлголтуудын хоорондын хамаарлыг харуулсан бүдүүвч зураарай.**

**Г. Зурсан бүдүүвчийг ашиглан өмчлөх эрхийг яагаад хуулиар хамгаалдаг вэ? үндэслэл гарган тайлбарлан бичээрэй**



.....

.....

.....

.....

.....

Хүн бүхэн их бага ямар нэгэн хэмжээгээр өөрийн гэсэн хөрөнгөтэй байдаг. Ажиллаж, хөдөлмөрлөсний үр дүнд хөрөнгө баялагийг бүтээн бий болгодог билээ.

**Даалгавар 2.** Эхийг уншаад цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй Үүнд:  
/ өмчийн эрх зүй, Иргэний хууль, өмчөө хамгаалж, өмчийн харилцаа, /

Хэн нэгэн ном үзгийг чинь дур мэдэн авах үед чи миний юм гэж хэлэх байх.  
Энэ нь ном үзэгний эзэн нь чи учраас ..... байна.  
Тэгвэл өмч гэж нэг талаас үзэг ном, барилга, бөмбөг зэрэг нүдэнд үзэгдэх эд юмсыг хэлнэ.  
Гэтэл нөгөө талаас уг биет зүйл нэг өмчлөгчөөс нөгөөд шилжиж, тэдний хооронд тодорхой харилцаа үүсдэг. Үүнийг бид .....гэдэг.  
Энэхүү харилцааг тодорхой хууль тогтоомжоор зохицуулсныг ..... гэнэ.  
Өмчлөх харилцааг ..... хуулиар зохицуулдаг

**Даалгавар 3.** Эх сурвалж 1 ба 2 -д тулгуурлан Хөрөнгийн ангиллыг харуулсан оюуны зураглалыг гүйцээн зураарай. / Сурах бичиг 11 анги, 76-77 –р талыг уншаарай /

**Эх сурвалж: 1**


“ Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртхууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно.”

*Иргэний хууль 83.1*

**Эх сурвалж: 2**

“ хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй”

*Монгол улсын Үндсэн хуулийн 16.3*




**Дүгнэлт:** Өмчийн эрх зүйн зохицуулалтыг танин мэдэх нь ямар ач холбогдолтой вэ?  
.....  
.....



Хэлцэл байгуулахгүйгээр өмчлөх эрх үүсэх **үндэслэлийг** Иргэний хуульд заасан байдаг

**Даалгавар 4.** Өмчлөх эрх үүсэх үндэслэлийг харуулсан бүдүүвчийг ашиглан тохиолдлуудыг шинжлэн хууль зүйн үндэстэй тайлбар хийнэ үү / Иргэний хуулийн 115-118 дугаар зүйлийг ашиглах/

А. Өмчлөх эрх үүсэх үндэслэлийг харуулсан бүдүүвчийг сайн уншиж, судлаарай



**Б. Дээрхи бүдүүвчийг ашиглан дараах тохиолдлуудыг асуултын дагуу задлан шинжилж, хүснэгтийг бөглөөрэй.**

**Тохиолдол 1:** Иргэн Ч Зөвлөлтийн цэргийн анги Монголоос гарах үедээ орхисон гахайн байрыг сумын захиргаанд мэдэгдэж засаж сэлбэж 7 жил тасралтгүй эзэмшсэн.

**Тохиолдол 2:** Малчин А шуурганд туугдаж яваа 300 хонь олоод нутгийн захиргаанд мэдэгдэж 1,6 жил маллав. Гэтэл алдууд хонины эзэн Б ирж бүх малаа төлийн хамт авна гэхэд А малын төл бол миний өмч гэв.

**Тохиолдол 2:** Иргэн Д автобусад явж байгаад 1,5 сая төг-ний үнэтэй гар компьютер олсон байна

Тохиолдол	Өмчлөх эрхтэй юу?	Өмчлөх эрх үүсэх үндэслэл	хууль зүйн үндэслэлтэй тайлбар бичих
1	тийм	Хуульд заасан эзэнгүй эд юмс олж авах	Эзэнгүй эд юмсыг хуулиар хориглоогүй аргаар олж авсан, эсхүл тухайн эд юмсыг олж авахдаа эрх бүхий этгээдийн эрхийг зөрчөөгүй бол эзэнгүй эд юмсыг олж авсан этгээд иргэний хуулийн 104.1, 104.2-т заасны дагуу түүнийг өөрийн эзэмшилдээ авч, өмчлөх эрхтэй.
2			
3			

**Даалгавар 5. Өмчлөх эрхээ хэрхэн хамгаалах вэ? Тохиолдлыг ушиж, асуултын дагуу шинжлээрэй**

**Тохиолдол 1**

Иргэн Д Говь-Алтай аймагт оршин суудаг. Тэр “Нарантуул” захаас 70 000 төгрөгөөр өвлийн гутал худалдан авч 3 өдөр өмссөн байна. Гэтэл гутлын ар талын хатуулгыг буруу нааснаас болж урагдсан. Иргэн Д худалдагчтай уулзаж энэ талаар хэлэхэд, “энэ гутлыг би үйлдвэрлээгүй, надаас шинэ гутал авсан, одоо өмсчихсэн тул буцаах, солих боломжгүй” гэв. Худалдагч Баянзүрх дүүрэгт оршин суудаг.

1. Иргэн Д –н ямар эрх зөрчигдсэн бэ ?
2. Иргэн Д эрхээ хэрхэн, яаж хамгаалах вэ?
3. Хэрэв та байсан бол асуудлыг хэрхэн шийдэх бэ ?
4. Иргэн Д шүүхэд нэхэмжлэл гаргахад юу бүрдүүлэх шаардлагатай вэ? Гүйцээн бичээрэй



5. Нэхэмжлэлийн загварыг ашиглан Иргэн Д ийн өмнөөс нэхэмжлэл бичээрэй



**Нэхэмжлэл бичих загвар**

..... Иргэний хэргийн анхан шатны шүүхэд  
нэхэмжлэл гаргах нь  
.....оны .....сарын .....өдөр .....\хот, аймаг, сум\

*Худалдах, худалдан авах гэрээнээс үйлдэлтэй  
хохирол гаргуулах тухай*

Нэхэмжлэгч: \_\_\_\_\_

Хариуцагч \_\_\_\_\_

Нэхэмжлэлийн утга \_\_\_\_\_

Нэхэмжлэлийн шаардлага: \_\_\_\_\_

Нэхэмжлэлийн бүрдүүлбэр:

1. Нэхэмжлэл 2 хувь
2. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
3. Мөнгө шилжүүлсэн баримт
4. ....

Нэхэмжлэл гаргасан \Гарын үсэг\




**Мэдээлэл 1.** Эрх зүйн зөрчил гэж хууль, дүрэм, журмыг зөрчсөн нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, гэм буруутай үйлдэл, эс үйлдлийг хэлнэ. Эрх зүйн зөрчлийг гэмт хэргийн, гэмт хэргийн бус зөрчил гэж ангилна. Гэмт хэргийн зөрчлийг зөвхөн эрүүгийн хуульд тусгаж, хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг. Гэмт хэргийн бус зөрчилд захиргааны, эд хөрөнгийн, сахилгын зөрчил хамаарна. Жишээ нь:

**Зохиогчийн эрхийг зөрчих**  
 Зохиогчийн эрхийг зөрчиж бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, худалдсан, түгээсэн, улсын хилээр нэвтрүүлсний улмаас зохиогч, эрх эзэмшигчид их хэмжээний хохирол учруулсан бол **гэмт хэрэг** болно.  
*Эрүүгийн хууль 2015*

**Зохиогчийн болон түүнд хамаарах эрхийн тухай хууль зөрчих**  
 Хэрэв зохиогчийн эрх зөрчсөн үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинж агуулаагүй бол **зөрчлийн** хуулиар хариуцлага хүлээлгэдэг.  
*Зөрчлийн тухай хууль 2017*


**Даалгавар 6.** Дээрхи мэдээлэл, эх сурвалжид тулгуурлан гэмт хэрэг, гэмт хэргийн бус зөрчлийн ялгаатай ба нийтлэг талыг Венн диаграмм –аар илэрхийлж, дүгнэлт бичнэ үү ? / Дараах зааврын дагуу гүйцэтгээрэй /

**Алхам №1**



Диаграмм 1. Гэмт хэрэг, гэмт хэргийн бус зөрчлийн онцлог, ба нийтлэг талыг жагсааж бичнэ

**Алхам №2**




Диаграмм 2 Онцлогийг харуулсан **жишээ гаргаж** харьцуулж бичих

**Алхам №3**




Өөрийн дүгнэлт, эргэцүүлэл, бичих

**Диаграмм 1**



**Диаграмм 2**



Дүгнэлт



## ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

**Заавар:** Асуулт бүрийг уншиж, тохирох түвшинд (✓) зөвлөж, тэмдэглэнэ. Арын тэмдэглэл хэсэгт нь ямар хугацаанд хэрхэн нөхөн гүйцээх, өөрөө болон найз нөхөд, багшаасаа авах дэмжлэг, тусламж зэргийг бичиж тэмдэглэх бөгөөд энэхүү мэдээллийг өөрийн сурах үйлийн төлөвлөлт боловсруулахад ашиглах юм.

Бүлэг сэдэв:	Дасгал даалгаврыг гүйцэтгэсэн чадвар	R	A	G	Comments
Эрх зүй	<ul style="list-style-type: none"><li>• Үндсэн хуульт ёс, эрх зүйд захирагдах ёсонд үндэслэн хүний эрхийг хангаж, хамгаалах, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх арга замыг нэрлэж, тайлбарлаж чадна</li><li>• Иргэний эрх зүй, өмчийн эрх зүйн, захиргааны эрх зүйн тулгуур ойлголтуудыг тодорхойлж чадна.</li><li>• Өгөгдсөн тохиолдлуудаас хүний эрх зөрчигдөж болзошгүй болон зөрчигдөж байгаа нөхцөл байдлыг олж тогтоон, эрх зүйн үүднээс тайлбар хийж чадна</li><li>• Эрх нь зөрчигдсөн тохиолдолд эрх зүйн ямар үйлдэл (өргөдөл, гомдол, нэхэмжлэл гэх мэт) хийж болохыг нэрлэж, тухайн нөхцөлд тохирох үйлдлийг оновчтой сонгон, загварын дагуу бичиж чадна</li></ul>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

R- багшийн тусламж авна

A- дахин давтаж нэмэлт дасгал ажиллана.

G- өөрөө сайн хийж чаддаг болсон

## Бүлэг сэдэв: 11-2-4. Эдийн засаг

### Бие даан суралцах үйлийн агуулга төлөвлөлт:

#### Хөтөч асуултууд

1. Төр эдийн засгийг ямар бодлогоор зохицуулдаг вэ?
3. Төрийн сангийн бодлогын зорилго юу вэ?
4. Төрийн мөнгө зээлийн бодлогын арга механизм юу вэ?
5. Үндэсний эдийн засгаа хөгжүүлэхийн тулд ямар хувилбар дэвшүүлэх вэ?
6. Гадаад худалдаа нь ямар ач холбогдолтой вэ? Ямар бодлогоор зохицуулдаг вэ?
7. Гадаад худалдаанд үүсдэг хүндрэлүүд, тэдгээрээс улс орнууд өөрийгөө ямар арга замаар хэрхэн хамгаалж ирсэн бэ?

#### Тулгуур ойлголтууд:

1. Төрийн сангийн бодлого
2. Төрийн мөнгө зээлийн бодлого
3. Төсөв
4. Гадаад худалдаа
5. Гадаад худалдааны бодлого
6. Эдийн засгийн хөгжил

#### Agenda:

1. Сурах бичгээсээ унших
2. Төле хичээл үзэх
3. Түүхийн хичээлтэй холбох
4. Цахим эх сурвалжаас найдвартай, албан ёсны сурвалж ашиглах
5. Дасгал даалгавраа хийж гүйцэтгэх
  - Мэдлэг ойлголтын даалгавар
  - Чадвар хэрэглээний даалгавар
  - Хандлага, төлөшлийн даалгавар
6. Өөрийн үнэлгээний хуудсаа тэмдэглэх
7. Хэрхэн сайжруулах төлөвлөгөө боловсруулах
8. Дэмжигч багшаас зөвлөгөө авах
- 9 хичээл заадаг багшаас тусламж авах
10. Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хөтлөөрэй

## 11-4-1а. Төрийн эдийн засгийн бодлого

## Даалгавар 1. Нэр томъёог тодруулах

**Заавар:** А баганын нэр томъёоны өмнөх цэгт Б баганын тодорхойлолтын эхний үсгийг бөглөж тохируулна уу. Тодорхойлолт бүрийн гол түлхүүр үгийг олж, доогуур нь зураарай

Санамж : Дээрх QR кодоор нэвтэрч сурах бичгийн 107-113 талыг сайн уншиж судлаарай

## А багана

## Б багана

- .....1. Нийт эрэлт
- ..... 2.Төсвийн бодлого
- ..... 3. Сангийн бодлого
- ..... 4. Улсын төсөв
- ..... 5. Татвар
- ..... 6. Бонд
- ..... 7. Мөнгийн хумих бодлого
- ..... 8.Мөнгөний тэлэх бодлого

- а. Хуулийн дагуу, тогтоогдсон хэмжээгээр бүх хүн, хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамж юм
- б. Тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохих хүүтэй эргүүлэн төлөхийн баталгаа болох үнэт цаас юм
- в. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын зарлагыг өөрчлөх бодлого.
- г. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлогыг төрийн мөнгө, зээлийн бодлого гэнэ.
- д. Гүйлгээнээс мөнгө татах буюу мөнгөний нийлүүлэлтийг бууруулах бодлого
- е гүйлгээнд мөнгө нэмж оруулах буюу мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого
- ё. Нийгэм, эдийн засгийн зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэл бөгөөд улсын мөнгөн хөрөнгийн төвлөрсөн хуримтлалыг бий болгож хуваарилж буй явдлыг хэлнэ.
- ж. Өрх гэр, пүүс, засгийн газар, гадаадын иргэдийн худалдан авахад бэлэн байгаа бараа үйлчилгээний бодит хэмжээ

## Даалгавар 2 Асуултанд хариулна уу


1. Эдийн засгийн уналтын үед бидний орчинд ямар ямар сөрөг үзэгдэл ажиглагддаг вэ?
2. Эдийн засгийн уналт, ажилгүйдэл, инфляцитай холбоотой асуудлыг зохицуулахад төр яагаад оролцох ёстой вэ?
3. Нийт эрэлтийн бүтцийг нэрлэнэ үү.
4. Нийт эрэлт ба эдийн засгийн өсөлт хоорондоо ямар хамааралтай вэ? Эдийн засагчид юу гэж тайлбарладаг вэ ?

Аливаа улс оронд нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн их байлгах зорилгоор 2 төрлийн эдийн засгийн бодлогыг төрөөс хэрэгжүүлдэг. Нэгт, засгийн газраас явуулж сангийн бодлого юм. Сангийн бодлого нь иргэд компаниудын төлж буй татварын мөнгөөр бүрдэж буй улсын төсвөөр хэрэгждэг тул төсвийн бодлого ч гэж нэрлэгддэг.

**Даалгавар 3** Сангийн бодлогын арга, механизмыг харуулсан бүдүүвчийг ашиглаж, гарах үр дагавартай нь зөв холбож, тайлбарлах

**Заавар:** А. Бүдүүвч дэх хоосон зайнд Б. тохирох үр дагавруудын дугаарыг бичнэ. Сурах бичгийн 108-109 талыг зэрэгцүүлж сайн уншиж даалгавраа хийнэ үү

А. Сангийн бодлогын **арга механизмыг** харуулсан бүдүүвч



Б. Сангийн бодлогын **арга замыг хэрэгжүүлснээр** гарах үр дагаврууд

1. Томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжсэнээр ажил эрхлэлт болон хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, нийт эрэлт өснө
2. Хэрэглэгчийн орлого, ААН-ийн орлого өсөж, хэрэглээний болон хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэж, нийт эрэлт өснө
3. Ажилгүй олон хүмүүс ажилтай болж, тэдний орлого нэмэгдсэнээр өрхийн хэрэглээний зардал өсөж, нийт эрэлт өснө
4. Төрөөс засгийн газрын бонд гаргах замаар санхүүжүүлдэг

**Даалгавар 4.** Асуудалд дүн шинжилгээ хийнэ үү

1. Эдийн засгийн огцом уналтаас гарахын тулд Засгийн газар татварын бодлоготой хамтруулан төрийн зардлыг огцом нэмэгдүүлэхийг хичээдэг. Ийм бодлогын давуу ба сул тал нь юу байж болох вэ?
2. Төрийн зардал, орлогоосоо давбал алдагдлыг бууруулахад чиглэсэн дараах шийдвэрээс хамгийн чухал гэж үзэж байгаа 2 арга замыг сонгож үндэслэлээ хамгаална уу.

- Төсвийн зардлыг хэмнэх .....
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх .....
- Төрийн өмчийн хөрөнгийг арилжих .....
- Мөнгө шинээр хэвлэж гүйлгээнд гаргах .....

Төрөөс хэрэгжүүлж буй нөгөө нэг эдийн засгийн гол бодлого нь төв банкуудын хэрэгжүүлдэг мөнгөний бодлого юм. Мөнгөний бодлого нь үнийн тогтвортой байдал буюу инфляцийг нам дор, тогтвортой байлгахад чиглэдэг


**Даалгавар 5 Мэдээлэл ба статистик үзүүлэлтийг хооронд нь харьцуулан судалж, төрийн мөнгө зээлийн бодлогыг шинжлэх**

Заавар: Сурах бичгийн 110-112 талыг уншиж, тэмдэглэж бичээрэй.

**Мэдээлэл 1:** Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит хуралдаанаар “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэлэлцэж, Засгийн газрын Дугаар 42 тоот тогтоолоор баталсан болно. Тус арга хэмжээний хэрэгжилтийг 2021 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар, авч үзвэл


А. Ажлын байрыг дэмжих зээлийн хувьд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш банкууд нийт **24.1 мянган зээлдэгчид 1.83 их наяд** төгрөгийн зээлийг олгоод байна. Ингэснээр улсын хэмжээнд нийт **101.1 мянган ажлын байрыг** хадгалсан гэж тооцож байна.

**Үйл ажиллагаа эрхлээгүй, түр зогсоосон болон бүрэн зогсоосон ахуйн нэгж, байгууллагын тоо /мянга/**



**Дүрслэл 2.10**

**Зээлийн өсөлт, салбаруудаар**



Эх сурвалж: Монголбанк

**Бодлогыг шинжлээрэй :** Эдийн засгийн уналтын үед мөнгө, зээлийн бодлогын ямар арга замыг хэрэгжүүлсэн бэ? Тухайн үед ямар шалтгаан нөхцөл үүссэн бэ ? Бодлогыг хэрэгжүүлснээр ямар үр дүн гарах вэ? гэсэн чиглүүлгээр дүн шинжилгээ хийж доорхи хүснэгтэд дүгнэн бичээрэй

Ажлын байрыг дэмжих зээл		ХАА-г дэмжих зээл	
Шалтгаан	Үр дагавар	Шалтгаан	Үр дагавар



## Даалгавар 6. Мэдээллийг шинжлэн, төрийн сангийн бодлогын ач холбогдлыг тодорхойлох

**1. Мэдээлэл:** Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд стратегийн ач холбогдолтой төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсад анх удаа нийт 2 их наяд хүртэлх төгрөгийн дүн бүхий төгрөг, валют хосолсон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ЭТТ бондыг гаргаж, эхний арилжаагаар 677.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүллээ. “Эрдэнэс Тавантолгой” ХК нь олон нийтэд нээлттэй хэлбэрээр 24-36 сарын хугацаатай, нэг бүр нь 100,000 төгрөг болон 100 ам долларын нэрлэсэн үнэтэй, 2 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий бондыг бүртгэсэн.

Эх сурвалж Зг-ын 100 хоногийн тайлан

### 2. Инфографик




Тавантолгой-Зүүн баян чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, Тавантолгойн дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх санхүүжилтийн эхний хэсгийг амжилттай бүрдүүлсэн

1. Засгийн газар төсвийн зарлагыг нэмэгдүүлэх зорилгоор дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд маш их мөнгө хэрэгтэй. Тэгвэл энэ мөнгийг төрөөс ямар арга замаар санхүүжүүлдэг вэ?

2. Дээрхи “Засгийн газрын төслийн” эх үүсвэр, зорилго, зориулалт нь юу вэ?

3. Улсын зардлыг нэмэгдүүлэх нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ? Дараах зүй тогтлыг харуулсан бүдүүвчийг гүйцээж, гаргалгаанд үндэслэж, эдийн засгийн үр ашгийг тодорхойлоорой



**Дасгал 7. Судалгааны үр дүнгийн шинжилгээнд тулгуурлан асуудлыг тодорхойлж, шинжлэн судлаарай**



Дүгнэлт: Өрхийн өрийн түвшин алгуур нэмэгдэж байна. Цар тахлын үед хэрэглээний зээл олголт хумигдаж, өрхийн өрийн түвшин хэрэглээний зээлийн хувьд багасав. Макро зохистой бодлогыг хэрэгжүүлж эхэлснээс хойш буюу 2019 оны эхнээс өрхийн өр алгуур буурах чиглэлд өөрчлөгдөж байсан бөгөөд цар тахал дэгдсэнээс хойш банкууд хэрэглээний зээл олголт хумьж, 2020 оны эцсийн байдлаар хэрэглээний зээл өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар буурсан байна.

*Эх сурвалж Монгол банк*

**1. Асуудлыг тодорхойлох .** Яагаад өрхийн өрийн түвшин алгуур нэмэгдсэн байна вэ?

.....

.....

.....

**2. Хэрэгтэй мэдээллээ цуглуулах.** Өрхийн өр нэмэгдсэн гол бэрхшээл, шалтгаан юу вэ?

.....

.....

.....

**3. Боломжтой шийдлүүдийг бичих.** Төрөөс энэ асуудлыг шийдэх ямар хувилбар дэвшүүлж чадах вэ? Боломжит арга замуудыг жагсаан бичих

.....

.....

.....

**4. Хувилбар бүрийн үр дагаварыг шинжлэх** Өрхийн өрийн багасгах хариуцлагыг ганцхан төр хариуцах ёстой юу, яагаад?

.....

.....

.....

**5. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах.** Хэрэв чи энэ асуудлыг шийдэх бол юу хийх вэ?

**Даалгавар 1. Улс орнууд яагаад өөр хоорондоо худалдаа хийдэг вэ? Үндсэн ойлголтуудаа сэргээн санаж дараах сорил, дасгалыг ажиллаарай.**

1. Эргэцүүлэн бодоод хариулаарай

А. Улс орон бүр өөрсдийн хэрэглэх зүйлээ өөрсдөө үйлдвэрлэж болохгүй гэж үү?

.....  
.....

Б. Хүмүүс ба улс орнууд хоорондоо мянга мянган жилийн турш өөр хоорондоо худалдаа наймаа хийж ирсэн. Худалдааны давуу ба сул тал юу вэ ?

.....

В. Яагаад олонхи улс орнууд чөлөөт худалдаа хийх асуудалд эмзэглэдэг вэ?

.....

.....

2. Нөхөн бичээрэй

А. Олон улсын худалдаа гэдэг нь.....хэлнэ.

В. Олон улсын худалдаа нь улс орнуудыг ..... болгосон

С. Олон улсын худалдаа нь ..... үр дүнд бий болсон.

А. Гадаад худалдааны тэнцэл гэдэг нь ..... хэлнэ.

Нөхөх үгс: ( харилцан хамааралтай, улс орон хоорондын бараа, үйлчилгээний шилжих хөдөлгөөн экспорт, импортын нийлбэр, Улс орнуудын нөөцын ялгаа )

3. Гадаадын худалдааны **үзэл баримтлалд** тохирох онол, төлөөлөгчдийн нэрийг сонгож байрлуулаарай.

Гадаад худалдаа хийх нь **яагаад ашигтай** байдаг вэ?

Дулаан уур амьсгалтай орнууд жимсийг, нефтээр баян орон нефтийг, аж үйлдвэр хөгжсөн орнууд аж үйлдвэрийн барааг экспортолдог болохыг энэ онолоор тайлбарладаг

Хэрэв А улс Б улстай харьцуулахад нөөцийн хамгийн бага зардлаар үйлдвэрлэдэг бол тэр нь туйлын давуу талтай байгаа хэрэг.

А. Онол: .....

С. Онол: .....

В. Төлөөлөгч: .....

Д. Төлөөлөгч: .....

Тохируулах үгс:

1. Харьцангуй давуу талын онол

2. Адам Смит /1723-1790/

3. Давид Рикардо /1772-1823/

4 Туйлын давуу талын онол

А. Манай улс ямар төрлийн бүтээгдхүүнийг ихэвчлэн экспортолдог вэ ? Харьцангуй, туйлын давуу талуудын хуулийн тусламжтай тайлбарлана уу ?

.....

.....

В. Яагаад манай улс Хятад улсаас хүнсний бараа, барилгын материал худалдан авч, оронд нь түүхий нүүрс нийлүүлдэг вэ? Харьцангуй давуу талын хуулийн тусламжтай тайлбарлана уу. Хоёр тал ийм худалдаанаас ямар ашиг олж байна вэ ?

.....

.....

**Даалгавар 2. Монгол улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт, гадаад худалдааны тэнцлийг тодорхойлж, динамик шинжилгээ хийж, дүгнээрэй**

№	Монгол улсын гадаад худалдаа, сая ам.долл.						
	Үзүүлэлт	2007	2008	2010	2012	2014	2016
1	Нийт эргэлт	?	?	?	?	?	?
2	Нийт экспорт	1947.5	2534.5	2908.5	4384.7	5774.3	4916.3
3	Нийт импорт	2061.8	3244.5	3200.1	6738.4	5236.7	3358.1
4	Гадаад худалдааны +ашиг (- алдагдал)	?	?	?	?	?	?

Гадаад худалдааны тоон үзүүлэлтийг харуулсан дээрхи хүснэгтэн мэдээллийг ашиглан дараах шинжилгээг хийнэ үү ?

а. Гадаад худалдааны **нийт бараа эргэлт** гэдгийг хэрхэн тодорхойлдог вэ? түүний хэмжээг тооцоолно уу

б. Гадаад худалдааны **ашгийн хэмжээг (алдагдлын хэмжээг)** хэрхэн тодорхойлж байна вэ?


в. Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлт, экспорт, импортыг графикийн аль нэг хэлбэрийг ашиглан (шугаман, баганан, туузан) нэг хавтгай дээр байгуулж тайлбарлаарай.

г. Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлтийн өөрчлөлтөд экспорт, импортын аль нь илүү хүчтэй нөлөө үзүүлж байна вэ? Үүний шалтгааныг тайлбарлаарай.

**Даалгавар 3. Гадаад худалдааны бодлогын зорилгыг тодорхойлж дараах дасгалуудыг ажиллана уу**

Дасгал 1. Эсрэг тэсрэг байр суурийг илэрхийлсэн 2 үзэл бодолтой танилцан, дараах асуултын дагуу өөрийн үзэл бодлыг тайлбарлана уу

Гадаадын компанийн үйлдвэрлэсэн биш Монголын бүтээгдхүүн ялангуяа хүнсний ногоог худалдан авах хэрэгтэй. Монголын ХАА-н үйлдвэрлэл хөгжиж байвал монголчууд л хожно



2  
Ямар улсад үйлдвэрлэсэн нь чухал биш зөвхөн хамгийн чанартайг нь худалдан авах хэрэгтэй. Эцсийн эцэст өрсөлдөөн л бүтээгдхүүний чанарыг сайжруулна. Нөөцөө ашигтай хувиарлахад нөлөөлнө. Үүнээс бүгд л хожно

1

А. Эхний үзэл бодол хэр зэрэг ухаалаг байна вэ? Дээрх үндэслэлд ямар нэг сул тал байна уу ?

Б. Хоёр дахь үзэл бодол хэр зэрэг ухаалаг байна вэ? Дээрх үндэслэлд ямар нэг сул тал байна уу?

В. Таны бодлоор аль үзэл бодол нь илүү үндэслэлтэй вэ? Хариултаа баримт жишээ гарган тайлбарлана уу

Г. Гадаад худалдааг зохицуулах бодлогыг веннийн диаграмм арга ашиглан ижил болон ялгааг харьцуулж, дэмжих, эсэргүүцэх үндэслэлүүдийг дэвшүүлнэ үү



**Даалгавар 4. Баримтад тулгуурлаж эсээ бичээрэй / дэвтэр дээрээ бичээрэй /**

- Заавар:** -Эсээнд ашиглах баримт мэдээллийг уншиж, гол санааг сайн ойлгоорой
- Эсээнд хөндөх асуудлаа оновчтой томъёолж, дэвшүүлээрэй
  - Доорхи чиглүүлэх асуултын дагуу баримтаас холбогдох үндэслэл сонгон шалтгааныг жишээгээр баяжуулж тайлбарлаарай
  - Аль болохоор өөрийн байр суурь, хандлагаа илэрхийлж бичээрэй

**Эсээнд ашиглах эх сурвалж:**

**Баримт1:** Монгол улсын экспортын талаас илүү хувийг зэсийн хүдэр, алт, түүхий нүүрс, нефть эзэлж байна. Энэ нь Монгол улс бусад орнуудтай харьцуулахад түүхий эдийн үйлдвэрлэлээр илүү давуу талтай байгааг нотолж байгаа хэдий ч боловсруулаагүй түүхий эдээ худалдах нь ашиггүй юм. Яагаад гэвэл, түүхий эдийг боловсруулж худалдсанаас олох нэмүү өртөг буюу ашиг манай оронд биш манай түүхий эдийг худалдан авч байгаа тэр оронд шингэж байна. Харин манай улс нефть биш бензин эсвэл масло, зэсийн хүдэр бус зэс утас, сэлбэг, материал үйлдвэрлэж худалдах нь ашигтай. Гэхдээ үүний тулд эдгээр барааны чанар дэлхийн стандартад нийцсэн байх учиртай.

**Баримт2:** Монгол улс өнөөдөр дэлхийн 146 оронтой худалдаа хийж гадаад худалдааны нийт эргэлт 8.3 тэрбум ам.долларт хүрчээ. Манай улсын экспортын хэмжээ жил ирэх тутам өсөж, дэлхийн 60 орчим улсад бараа, бүтээгдэхүүн экспортолж байгаа бөгөөд эхний 5 байрыг Хятад, Их Британи, Швейцарь, ХБНГУ, ОХУ зэрэг улсууд эзэлж байна. Экспортоор орж ирж байгаа бүх орлогыг үндсэн ганц, хоёр бараанаас бүрдүүлж байгаа бол энэ нь маш аюултай юм. Монгол улсын экспортын орлого нь жишээ нь, зэс, нүүрс, алтны дэлхийн зах зээлийн үнийн түвшнээс хүчтэй хамаардаг. Эдгээрийн үнэ дэлхийн зах зээлд унаснаар манай орны гадаад худалдааны байр суурь хүчтэй суларч энэ хэмжээгээр эдийн засаг доройтдог.

**Баримт 3:** Монгол улс өнөөдөр дэлхийн 120 гаруй улсаас бүтээгдэхүүн импортолж байгаа бөгөөд эхний 5 байрыг Хятад, АНУ, ОХУ, Япон улсууд эзэлж байна. Сүүлийн жилүүдэд импортын хэмжээ экспортын өсөлтөөс илүү хурдацтай өсөж байгаа нь нэг талаас дотоодод уул уурхай, дэд бүтцийн салбарын томоохон бүтээн байгуулалт, төслүүд хэрэгжиж, тэдгээрт шаардлагатай машин, техник, тоног төхөөрөмж болон дизель түлшний импорт өсөж байгаатай холбоотой байна.

**Чиглүүлэх асуултууд:**

1. Манай улсын гадаад худалдаанд анхаарал татсан ямар асуудлууд байна вэ?
2. Энэ асуудлыг шийдэхэд өөр ямар хүндрэл бэрхшээл гарч байна вэ?
3. Манай улсын гадаад худалдааны өнөөгийн бүтцийг сайжруулах ямар боломж байна вэ?
4. Гадаад худалдааны бодлогын ямар арга механизмыг хэрэгжүүлж байна вэ?
5. Монгол улсын гадаад худалдааны үр ашгийг дээшлүүлэхийн тулд бид цаашид юу хийх ёстой вэ?



## ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

**Заавар:** Асуулт бүрийг уншиж, тохирох түвшинд (√) зөвлөж, тэмдэглэнэ. Арын тэмдэглэл хэсэгт нь ямар хугацаанд хэрхэн нөхөн гүйцээх, өөрөө болон найз нөхөд, багшаасаа авах дэмжлэг, тусламж зэргийг бичиж тэмдэглэх бөгөөд энэхүү мэдээллийг өөрийн сурах үйлийн төлөвлөлт боловсруулахад ашиглах юм.

Бүлэг сэдэв:	Дасгал даалгаврыг гүйцэтгэсэн чадвар	R	A	G	Comments
Эдийн засаг	<ul style="list-style-type: none"><li>Төрийн сангийн болон мөнгө зээлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга механизмыг тайлбарлаж чадна</li><li>Сангийн болон мөнгө, зээлийн бодлогын ялгааг бүдүүвчээр илэрхийлж, харьцуулалт хийн, жишээгээр тайлбарлаж чадна</li><li>Гадаад худалдаа, гадаад худалдааны бодлого, тэдгээрийг илэрхийлэх ойлголт, статистик тоон үзүүлэлтийг тайлбарлаж чадна</li><li>Гадаад худалдаа нь ямар ач холбогдол хийгээд түүний эерэг, сөрөг талыг тодорхойлж, өөрийн санал бодлоо оновчтой илэрхийлж чадна</li><li>Эдийн засгийн хөгжлийн тухай ойлголтоо эсээгээр илэрхийлж чадна</li></ul>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

R- багшийн тусламж авна

A- дахин давтаж нэмэлт дасгал ажиллана.

G- өөрөө сайн хийж чаддаг болсон

**Хөтөч асуултууд:**

1. Иргэний нийгэм гэж юу вэ
2. Иргэний нийгэм ямар үндсэн шинжтэй вэ?
3. Сонгууль гэж юу вэ? Сонгуулийн ямар үндсэн зарчмууд байдаг вэ?
4. Сонгуулийн тогтолцоо ямар онцлогтой байдаг вэ?
5. Хэвлэл мэдээлэл гэж юу ямар үүрэг, нөлөөтэй вэ?
6. Улс төрийн систем ямар бүтэц, бүрэлдхүүнтэй вэ?
7. Улс төрийн институт ямар үйл ажиллагаа, чиг үүрэгтэй вэ?

**Тулгуур ойлголтууд:**

1. Иргэний нийгэм
2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
3. Сонгууль, сонгуулийн систем
4. Улс төрийн үйл явц
5. Улс төрийн систем
6. Улс төрийн институт
7. Улс төрийн нам
8. Сонирхолын бүлэг

**Agenda:**

1. Сурах бичгээсээ унших
2. Теле хичээл үзэх
3. Түүхийн хичээлтэй холбох
4. Цахим эх сурвалжаас найдвартай, албан ёсны сурвалж ашиглах
5. Дасгал даалгавраа хийж гүйцэтгэх
  - Мэдлэг ойлголтын даалгавар
  - Чадвар хэрэглээний даалгавар
  - Хандлага, төлөвшлийн даалгавар
6. Өөрийн үнэлгээний хуудсаа тэмдэглэх
7. Хэрхэн сайжруулах төлөвлөгөө боловсруулах
8. Дэмжигч багшаас зөвлөгөө авах
9. Хичээл заадаг багшаас тусламж авах
10. Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хөтлөөрэй



**Даалгавар 1. Эргэцүүлэн бодоод, хариулж бичээрэй**

Монгол улсын үндсэн хууль (1992)- д “ Монголын ард түмэн бид:...**эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно**” хэмээн заасан.

- 1.Хүмүүнлэг нийгэм гэж ямар нийгмийг хэлэх вэ ?
2. Иргэний ардчилсан нийгэм гэж ямар нийгмийг хэлэх вэ?
- 3.Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулахад бид ямар үүрэг, оролцоотой вэ?

**Даалгавар 2** Иргэний нийгмийн ойлголт эртний анх Грек Ромын үед үүсжээ. XVIII-XX зуунд улс төрийн шинжлэх ухааны бие даасан ойлголт болсон. Дараах сэтгэгчид иргэний нийгмийн мөн чанарыг хэрхэн тодорхойлсон бэ? Матриц хүснэгтийн аргаар харьцуулан шинжилж, дүгнэлт бичээрэй

**Заавар:**

1. Сурах бичгийн 140 талын холбогдох мэдээллийг уншиж, доорхи зааврын дагуу матриц хүснэгт дээр ажиллаарай
2. Хүснэгтийн мөр, баганын дагуу мэдээллээ цэгцлээрэй. Үүнд:
  - В - мөрөнд эхлээд **сэтгэгчдийн тодорхойлолтыг** гүйцээн бичих дараа нь тодорхойлолт дахь **гол түлхүүр** үгийг олж, доогуур зурах
  - С- тодорхойлолт дахь хамгийн **гол шинжийг** ялгаж бичих
  - Д.- мөрөнд дээрхи 3 сэтгэгчдийн тодорхойлолт дахь гол шинжүүдийг харьцуулан, **нэгдсэн дүгнэлт** бичих

**Матриц хүснэгт**

<b>Иргэний нийгэм гэж юу вэ? Эртний сэтгэгчдийн тодорхойлолт</b>			
<b>А</b>	<b>Г. Гегель</b>	<b>Р.Дарендорьф</b>	<b>Р.Путнам</b>
<b>В</b>	Иргэний нийгэм нь <b>төрөөс үл хамаарах өөр</b> хоорондын харилцаа эрх зүйгээр зохицулагддаг <b>хувь хүмүүс, анги, бүлэг, институтын нийлбэр цогц юм</b> гэсэн байдаг.		
<b>С</b>	<b>Төрөөс үл хамаарах</b>		
<b>Д</b>	Нэгдсэн дүгнэлт:		

### Даалгавар 3. Тохиолдлыг задлан шинжлээрэй

1990-ээд оноос хойш Монгол улсад алт олборлолт эдийн засгийн сонирхлыг ихээр татаж эхэлсэн юм. Хэдийгээр алт олборлолтын салбар нь олон өрхийн амьжиргааг хангаж байгаа ч нэлээдгүй уурхайнууд зохицуулалтгүйгээр ажиллаж байгаас олон тооны гол ус, нуур цөөрөм ширгэж, алга болжээ. Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг А компани гурван аймгийн нутгийг дамжин урсдаг Х голын эхэнд алт олборлох зөвшөөрлийг саяхан авчээ. Иргэд энэ тухай мэдсэний дараагаар уг асуудалд янз бүрээр хандан маргалдах болсон аж. Зарим нь орон нутагт нь хөрөнгө оруулалт орж байна хэмээн талархангуй хандаж байсан бол нөгөөдүүл нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй хэмээн үзэж уг компанийн үйл ажиллагааг эсэргүүцэж байлаа. Энэхүү маргааныг таслах үүднээс Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олон нийтийн форум зохион байгуулсан бөгөөд уг форумд дараах төлөөлөгчид оролцсон байна. Үүнд:

1. Байгаль орчны яамны төлөөлөл
2. Уул уурхайн компанийн төлөөлөл
3. Сэтгүүлч
4. Аймгийн ЗДТГ-ын төлөөлөл -1
5. Аймгийн ЗДТГ-ын төлөөлөл- 2
6. Иргэний нийгмийн төлөөлөл -1
7. Иргэний нийгмийн төлөөлөл -2
8. Их сургуулийн профессор
9. Сумын ЗДТГ-ын ажилтан
10. Багийн ЗД-ын төлөөлөл

1. Ямар асуудлыг хөндсөн байна вэ?
2. Олон нийтийн формыг ямар зорилгоор зохион байгуулсан бэ?
3. Ямар талууд оролцсон бэ? 3 ялгаатай төлөөлөгчийг сонгож, тэдний байр суурийг тодорхойлно уу?
4. Эрх ашгийн ямар ялгаатай байдал илэрч байна вэ?
5. Иргэний нийгмийн хяналт тавих нь ямар ач холбогдолтой вэ?

**Даалгавар 4. Бүдүүвч дэх мэдээллийг ашиглан иргэний нийгмийн орчин хэр төлөвшиж буйг Тэнхлэгийн аргаар хөрвүүлэн үнэлэхэрэй**



**ИРГЭНИЙ НИЙГМИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭ**

Хувийн өмч  
Бизнес эрхлэх  
Шударгаар өрсөлдөх



Эдийн засгийн хүрээнд



Нийгмийн хүрээнд

Хүний эрх, эрх чөлөө  
Эвсэл холбоо, ТББ, эрхзүйн орчин

Иргэдийн боловсрол  
Хэвлэн нийтлэх  
Мэдээлддгий н орон зай



Оюунсанааны хүрээ



Улс төрийн хүрээнд

Сайн засаглал  
Шударга сонгууль  
Иргэдийн оролцоог хангах

1. Иргэний нийгэм төлөвшүүлэх төрийн бодлогын хүрээ дээрхи бүдүүвчийг ( Сурах бичгийн 142 талыг нэмж унших ) судалж, манай нийгэмд иргэний нийгэм төлөвших орчин хэр сайн бүрдэж байгааг дараах тэнхлэгт үнэлэн бичээрэй



**ИРГЭНИЙ НИЙГЭМ ХЭР ТӨЛӨВШИЖ БАЙНА ВЭ**



2. Эх орондоо Иргэний нийгэм төлөвших орчныг бүрдүүлэхийн тулд иргэд бид өөрсдөө хэрхэн идэвхтэй оролцох вэ? Шинэ санаа дэвшүүлж, үндэслэлийг тодорхойлно уу?



.....  
.....

### Даалгавар 5. Эргэцүүлэн бодоорой

Монгол Улсын Үндсэн хуулиар “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын бүх ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан байдаг.

1 Сонгууль гэж юу вэ? хүмүүс ямар зорилгоор сонгууль явуулдаг вэ?

2. Яагаад сонгуульд илүү их ач холбогдол өгдөг вэ ?

3. Хүмүүсийн амьдралд сонгууль ямар ач холбогдолтой юм бэ?

### Даалгавар 6. Сонгуулийн зарчмыг тайлбартай нь зөв харгалзуулаарай, Гол түлхүүр үгийг олж доогуур нь зураарай

Нас, хүйс яс үндэс, гарал угсаа, мэргэжил хэл, санхүүгийн чадвар, үзэл бодлоос үл шалтгаалан бүгд оролцдог байх	Саналаа нууцаар гаргах зарчим
Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд санал бүр адил жинтэй байх	Чөлөөтэй сонгох зарчим
Сонгуулийн эцсийн үр дүн нь зөвхөн иргэдийн санал хураалтын үр дүнгээр шийдэгддэг байх	Саналыг шууд өгөх зарчим
Сонгуульд оролцохдоо чөлөөтэй сонголтоо хийн, саналаа чөлөөтэй илэрхийлэх бүхий л бололцоогоор хангагдах ёстой.	Тэгш оролцох зарчим
Сонгогч бүр ямар нэгэн дарамт шахалтгүйгээр гагцхүү өөрийн үзэмжээр саналаа өгөх явдлыг хангах хэрэгтэй	Бүх нийтээр оролцох зарчим

### Даалгавар 7. Сонгогдсон албан тушаалтныг үнэлэх

А. Сонгуулиар сонгогддог албан тушаалтныг сонгохдоо ямар шалгуурыг баримтлан үнэлэх нь зохистой вэ?

А. Өөрийн баримталж буй гол шалгуурыг жагсаан бичээрэй

Б. Өөрийн амьдарч байгаа тойргоос сонгогдсон аль 2-3 албан тушаалтныг дээрхи шалгуурыг баримтлан үнэлнэ үү

## Даалгавар 8. Баримтыг судлан асуултын дагуу дүн шинжилгээ хийнэ үү

### Баримт:

1. **1992** оны УИХ-ын сонгуульд МАХН /одоогийн МАН/ нийт сонгогчдын **53%**-ийн санал авсан ч парламентын суудлын **92,1%** буюу **70**-ыг авч байсан бол бусад нам эвсэлүүд нийт сонгогчдын **47%**-ийн санал авсан хэдий ч парламентад **6** суудал авч байсан.
2. **2000** оны УИХ-ын сонгуульд МАХН /одоогийн МАН/ нийт сонгогчдын **52%**-ийн санал авсан ч парламентын суудлын **94,7%** буюу **72**-ыг авч байсан бол бусад нам эвсэлүүд нийт сонгогчдын **48%**-ийн санал авсан хэдий ч парламентад **4** суудал авч байжээ.
3. **2016** оны УИХ-ын сонгуульд МАН нийт сонгогчдын **45,69%**-ийн санал авсан ч парламентын суудлын **85,5%** буюу **65**-ыг авч байсан бол бусад нам эвсэлүүд нийт сонгогчдын **54,31%**-ийн санал авсан хэдий ч парламентад **11** суудал авч байжээ.

Дүн шинжилгээ хийнэ үү:

1. Энэ 3 баримт сонгуулийн ямар тогтолцооны онцлогийг харуулж байна вэ?
2. Сонгогчдын саналыг их авсан ч парламентын суудал бага авч байгаа шалтгааныг тайлбарлана уу

## Даалгавар 9 .Сонгуулийн тогтолцооны давуу ба сул талыг тодорхойлох

### Заавар:

1. Мажоритари тогтолцооны онцлог талуудыг жагсаалтыг анхааралтай уншина.
2. Пропорционал тогтолцооны онцлогоос оруулсан байгаа алдааг олж, доогуур харандаагаар зурж , тодруулна уу?
3. Яагаад хамрагдахгүй гэж үзсэнээ сонгууль, сонгуулийн тогтолцооны мэдлэг, ойлголтоо ашиглан үндэслэл гарган тайлбарлаарай ?
  1. Өрсөлдөгчөөсөө олон санал авсан улс төрийн намд дангаараа Засгийн газар байгуулах боломжийг түлхүү олгодог.
  2. Улс төрийн намуудыг бодлогын өрсөлдөөнд дуудаж, төлөвшүүлдэг
  3. Засгийн газрыг илүү тогтвортой байлгахад нөлөөлдөг.
  4. Парламентын гишүүд тойргийн сонгогчдоосоо хараат байдалтай.
  5. Сонгогчдын тодорхой хэсгийн дэмжлэг авсан улс төрийн нам парламентад суудал авах боломжтой тул олон намын тогтолцоо төлөвшихөд нөлөөлнө.
  6. Улс төрийн намууд парламентад эзлэх суудлын хувь нь нийт сонгогчоос авсан саналын хувиас ихээхэн зөрүүтэй байдаг

---

---

---

**Даалгавар 10. Улс төрийн системийн онолын үзэл баримтлалын холбоо хамаарлыг шинжилж, өгөгдсөн маягтаар өөрийн дүгнэлтийг дэлгэрүүлж бичээрэй**



Д.Истон

Улс төрийн систем нь: **оролт, гаралт, хувиргалт, эргэх холбоо** гэсэн үндсэн бүрдэл хэсгүүдээр илэрхийлэгдэж байна.

бодит байдал дээр хэрэгжүүлэгчид **иргэд, сонирхлын бүлгүүд, улс төрийн нам, төр, хэвлэл мэдээлэл**



Людвиг фон Берталанфи

**Эд эсийг судлан**, түүнийг харилцан хамааралтай элементүүдийн нийлбэр цогц буюу гадаад орчинтой холбоотой систем гэж тодорхойлсон байна.

системийг бүрдүүлэгч **нэг л элемент** өөрчлөгдсөнөөр **бусад хэсгүүд** нь өөрчлөгдөж, улмаар **бүтцийг бүхэлд** нь өөрчлөхөд хүргэнэ



К. В. Дойч

Улс төрийн системийн хамгийн гол **зорилго нь** нийгмийн нэгдлийг хангахад оршино. Нийгмийн нэгдлийг хангахад **хэвлэл мэдээлэл** онцгой чухал үүрэгтэй.

ХМ- нь: Засаглалын бүтэц, улс төрийн субъектуудын **өвөрмөц нөөц мөн**.  
· Улс төрийн субъектуудын ашиг сонирхлыг хэрэгжүүлэх **зэвсэг буюу хэрэгсэл** мөн.



Г. Алмонд

Улс төрийн системийн чиг үүргийг 3 ангилалд авч үзсэн

1. Оролтын чиг үүрэг
2. Системийн чиг үүрэг
3. Гаралтын чиг үүрэг

1. .... гэх ойлголт анх биологийн шинжлэх ухаанд үүссэн. Эрдэмтэн ..... судалсан.

2. Дээрхи онолын үзэл баримтлалд -----ний тухайд бүгд адилхан судалсан байлаа  
Д. Истон ----- д----- ийн тухай----- гэж үзсэн байна.  
Мөн “-----нд-----ний тухайд ----- гэсэн байв”. Эндээс үзэхэд-----ажээ”

3. .... хэвлэл мэдээллийг -----үзсэн. Үүнийг Истон ----- гэж тодорхойлсон

4. .... Оролтын чиг үүргийг .....  
..... гэж тодорхойлсон. Эцэст дүгнэж үзэхэд .....

## Бататгах сорил

- Тэгш оролцох сонгуулийн зарчмыг тэмдэглэнэ үү.
  - Сонгуулийн эцсийн үр дүн нь иргэдийн санал хураалтаар шийдэгдэх
  - Нас хүйс, яс үндэс, мэргэжил, үзэл бодлоос үл шалтгаалан оролцох
  - Сонгогч бүр ижил тооны санал гаргах, санал бүр адил жинтэй байх
  - Чөлөөтэй сонголт хийн саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх
  - Сонгогч зөвхөн өөрийн сонголтоор саналаа өгөх боломжтой байх
- Сонгогчдоос хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ялсанд тооцдог сонгуулийн тогтолцоо аль нь вэ?
  - Хувь тэнцүүлэх
  - Харьцангуй олонх
  - Үнэмлэхүй олонх
  - Энгийн олонх
  - Саналыг харгалзах
- Сонгогчдоос 50-аас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг ялсанд тооцдог сонгуулийн тогтолцоо аль нь вэ?
  - Саналыг харгалзах
  - Харьцангуй олонх
  - Үнэмлэхүй олонх
  - Хувь тэнцүүлэх
  - Энгийн олонх
- Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээллийн гүйцэтгэх чиг үүрэгт хамаарахгүй өгөгдлийг тэмдэглэнэ үү
  - Үзэл суртал номлох
  - Шүүмжлэл өрнүүлэх
  - Хяналт тавих
  - Мэдээлэл олгох
  - Боловсрол олгох



### ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Дэд сэдэв	Дасгал даалгаврыг гүйцэтгэсэн чадвар	R	A	G	Comments
Соёлын үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none"> <li>Соёлын үйлдвэрлэл түүнийг бүтээхэд оролцдог хувь хүн, байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүргийг мэднэ</li> <li>Соёлын үйлдвэрлэлд хамаарах тоон үзүүлэлтүүдэд үндэслэж, ДНБ-д оруулах хувь нэмрийг тооцоолж чаддаг</li> <li>Соёлын үйлдвэрлэлийн ач холбогдлыг жишээнд тулгуурлан тодорхойлж чадна</li> <li>Манай оронд соёлын үйлдвэрлэл үйлчилгээний байгууллагыг хөгжүүлэх давуу болон сул талыг ялгаж, өөрийн дүгнэлтийг хэлж чадна</li> <li>Соёлын аялал жуулчлал, түүнд тавигддаг зарчмуудыг тодорхойлж мэднэ</li> <li>Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх тулгамдаж буй асуудлын шалтгааныг тодорхойлж, шийдэх гарц шийдлийг дэвшүүлж чадна</li> </ul>				

R- Багшийн тусламж авна

A- Дахин давтаж, нэмэлт дасгал ажиллана.

G- Өөрөө сайн хийж чаддаг болсон

### Хөтөч асуултууд:

1. Олон улсын харилцааны улс бус оролцогч гэж юуг ойлгох вэ?
2. Улс бус оролцогч бүрийн үйл ажиллагаа ямар онцлогтой вэ?
3. Манай улс улс бус оролцогчидтой хэрхэн хамтран ажиллаж байна вэ ?
4. Монгол улсын гуравдагч хүчний бодлого гэж юу вэ?
5. Манай улс “ гуравдагч хөрш” орнуудтай хэрхэн хамтран ажиллаж байна вэ?
6. “Зөөлөн хүчний бодлого гэж юу вэ? ямар чиглэлээр хэрэгжиж байна вэ?
- 6.”Зөөлөн хүчний” гадаад бодлого ямар ач холбогдолтой вэ? Манай улсад хэрхэн нөлөөлж байна вэ?

### Тулгуур ойлголтууд:

1. Олон улсын харилцаа
2. Олон улсын харилцааны улс бус оролцогч
3. Олон улсын эрх зүй
4. Гуравдагч хөршийн бодлого
5. Төвийг сахих бодлого
6. Зөөлөн хүчний бодлого
7. Хатуу хүч
8. Ухаалаг хүчний бодлого

### Agenda:

1. Сурах бичгээсээ унших
2. Теле хичээл үзэх
3. Түүхийн хичээлтэй холбох
4. Цахим эх сурвалжаас найдвартай, албан ёсны сурвалж ашиглах
5. Дасгал даалгавраа хийж гүйцэтгэх
  - Мэдлэг ойлголтын даалгавар
  - Чадвар хэрэглээний даалгавар
  - Хандлага, төлөвшлийн даалгавар
6. Өөрийн үнэлгээний хуудсаа тэмдэглэх
7. Хэрхэн сайжруулах төлөвлөгөө боловсруулах
8. Дэмжигч багшаас зөвлөгөө авах
9. Хичээл заадаг багшаас тусламж авах
10. Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хөтлөх



**Даалгавар1:** Эргэцүүлэн бодоорой

1. ОУХ-нд **ОУБ, ТББ, иргэд** хувь хүн яагаад оролцдог вэ? **бүрэн эрхт улс** оролцогчоос ямар ялгаатай вэ?
2. Улс бус оролцогчдын ямар төрлүүд байдаг вэ? Ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?
3. ОУХ-ны улс бус оролцогчид ямар эрх зүйн хэмжээ баримталдаг вэ?

**Даалгавар2:** Олон улсын харилцааны зарим тулгуур ойлголтуудын мөн чанарыг судлаарай

1. Тулгуур ойлголтуудыг тодорхойлолтой нь зөв тохируулж өмнөх цэгийн оронд тохирох үсгийг нөхөж тэмдэглээрэй. Гол түлхүүр үгийг олж доогуур нь зураарай.

- .....1. Олон улсын харилцаа
- .....2. Улс оролцогч
- .....3. Улс бус оролцогч
- .....4. Олон улсын төрийн бус байгууллага
- .....5. Үндэстэн дамнасан корпорац (ҮДК)
- .....6. Олон улсын эрх зүй


- а. Хувийн, сайн дурын үндсэн дээр бий болсон, үүрэг даалгаварт чиглэсэн олон нийтийн байгууллага юм.
- б. Олон улсын харилцаа даяаршихын хэрээр олон улсын улс төр, эдийн засгийн харилцаанд ихээхэн нөлөө үзүүлэх болсон субъектын нэг
- в. Засгийн газрын оролцоо, дэмжлэггүйгээр улс, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчид, тоглогчид, олон улсын байгууллагыг хамруулан үздэг.
- г. ОУХ-нд оролцогчдын хоорондын харилцааг зохицуулдаг хууль зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцоо юм.
- д. Олон улсын харилцааны үндсэн оролцогч нь бүрэн эрхт тусгаар тогтносон улс байдаг.
- е. Дэлхийн улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад бодлого, үйл ажиллагааг судалдаг шинжлэх ухааны салбар юм.

2. Тулгуур ойлголтуудаас 2-3 ыг сонгож, тодорхойлолтыг дэлгэрүүлэн амьдралын бодит жишээ баримтаар тайлбарлаарай

1. -----
2. -----
3. -----

**Даалгавар3 : Улс бус оролцогчдын ангиллыг төсөөллийн зураглал аргаар бүтээж гүйцээгээрэй. /Сурах бичгийн 168-171 талыг сайн уншиж, даалгавраа гүйцэтгээрэй /**

- Аргачлал: Төсөөллийн зураг**
1. Гол хэсэгт дэх сэдэвтэй хамаатай улс бус оролцогчид
  2. 3 дахь хэсэгт: хамаарах жишээ байгууллага тус бүрийг сайн судлах
  3. Хоосон нүдийг гүйцээж нөхөж бичих



- Санаа гаргах
- Дэлгэрүүлэх
- Харилцан холбоо
- Уялдаа холбоо
- Үнэлэх



Улс бус оролцогчдын мэдлэг, ойлголтоо дэлгэрүүлж дараах асуултын дагуу өөрийн үзэл бодлоо илэрхийлнэ үү?

Асуултууд:

1. Улс бус оролцогч 2-3 ыг сонгож, үйл ажиллагааны онцлогийг дэлгэрүүлж бичнэ үү

1. ....

2. ....

3. ....

2. Үйл ажиллагааны чиглэл, онцлогт тулгуурлан хоорондын уялдаа холбоо, хамаарлыг тодорхойлно уу ?

.....

.....

**Даалгавар 4 : Улс бус оролцогчдын талаар баримт, мэдээлэлд тулгуурлан манай улсын амьдралд үзүүлэх үр нөлөөг тодорхойлж, үнэлэлт өгөөрэй**

**1. Баримт:** МҮОНРТ Хятадын “SGTN”, БНСУын “Arirang”, ОХУ-ын “Russia Today”, Японы “JAMCO”, “AP”, “SNTV” зэрэг мэдээллийн агентлагуудтай контент солилцооны чиглэлээр ажиллаж, “Asia-Pacific Broadcasting Union”, “Asia-Pacific Institute of Broadcasting development” зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, МОНЦАМЭ агентлаг монголын тухай мэдээ мэдээлэл, 7 хоног тутмын хэвлэмэл бүтээгдэхүүнээ Японы Киодо Цүүшин агентлаг, Майничи, Никкей, Токио сонинууд болон ОХУ-ын ТАСС, Риа Новости, Хятадын Синьхуа, БНСУын Ёнхап, БНСВУ-ын ВМА, БНКуБУын Пренса Латина, БНАСАУ-ын СТМА зэрэг агентлагт тогтмол нийлүүлж байна

Эх сурвалж: Гадаад харилцааны яам /<https://mfa.gov.mn/>

**2.Мэдээлэл:** Монгол орны хөгжилд” XVI чуулга уулзалтыг “Монгол Улс – Тогтвортой хөгжил” сэдвийн хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд ИБУИНХУ-ын Лондон хотноо цахимаар зохион байгуулав. Монгол, Австрали, Англи, Герман, Швед, Өмнөд Солонгос, Бельги, Ирланд, Итали, Польш, Унгар, Япон зэрэг улсад оршин сууж буй 300 гаруй монгол иргэд, монголчуудын холбоодын төлөөлөл оролцсон



“Монгол орны хөгжилд” XVI цахим чуулга уулзалт, ИБУИНХУ-ын Лондон хот, 2020.12.05

1. Баримт 1, Мэдээлэл 2 –т ямар улс бус оролцогчдыг тухай дурьдаж байна вэ?

-----

-----

2. Дээрх 2 баримт мэдээллийг судлан матриц хүснэгтэд холбогдох мэдээллийг хөрвүүлэн дүн шинжилгээ хийнэ үү ?

	Баримт 1	Мэдээлэл2
1. Байгууллагын зорилго		
2. Гол үйл ажиллагаа		
3. Түүний үр дүн		

3. Дээрхи матриц хүснэгтийн дагуу хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан Улс бус оролцогч байгууллагын үйл ажиллагаа нь манай улсын амьдралд хэрхэн нөлөөлж байгааг өөрийн үзэл бодлоор үнэлж, дүгнэлт бичээрэй

-----

-----

-----

-----

**Даалгавар 1: Эргэцүүлэн бодоорой**

1. Монгол улс яагаад “ гуравдагч хөршийн бодлогыг гадаад харилцаандаа баримтлах болсон бэ?
2. Монгол улс “ гуравдагч хөрш – тэйгээ хэрхэн хамтарч ажиллаж байна вэ?
3. Зөөлөн хүчний бодлого гэж юу вэ? Яагаад олон улсын харилцаанд чухал нөлөөлөл үзүүлдэг вэ ?

**Даалгавар 2: Олон улсын харилцааны зарим тулгуур ойлголтуудын мөн чанарыг шинжлээрэй**

1. Тулгуур ойлголтуудыг тодорхойлолтой нь зөв тохируулж өмнөх цэгийн оронд тохирох үсгийг нөхөж тэмдэглээрэй. Тодорхойлолтын гол мөн чанарыг харуулсан гол түлхүүр үгийг олж доогуур зураарай.

- .....1.Гуравдагч хөршийн бодлого
- .....2. Зөөлөн хүч
- ..... 3. Хатуу хүч
- .....4. Ухаалаг хүчний бодлого

- а. Их гүрнүүд цэрэг, эдийн засгийн хүч чадавхдаа тулгуурлан хүчээр түрий барих бодлого хэрэгжүүлэхийг хэлнэ.
- б. Улс өөрийн үндэсний ашиг сонирхол, гадаад бодлогын зорилгоо хэрэгжүүлэхдээ өөрт байгаа улс төр, стратеги, эдийн засаг, соёл зэрэг бүх арга хэрэгслээ тэнцвэртэй хоршуулах чадвар юм.
- в. Албадлага, урамшууллаар бус харин бусад улсын сэтгэлийг өөртөө татах замаар өөрийн хүсэж буй үр дүнд хүрэхийн тулд бусдад нөлөөлөх чадвар юм.
- г. Монгол улс зөвхөн хоёр хөршийн хамаарал дор байх ёсгүй, хоёр хөршийн нөлөөллийн зохих тэнцвэрийг хадгалахад хүч буюу нөлөөлөл байх ёстой гэсэн үзэл санааны үүднээс 1990 оноос баримталж ирсэн шинэ бодлого юм.

2. Тулгуур ойлголтуудаас 2-3 ыг сонгож, тодорхойлолтыг дэлгэрүүлэн амьдралын бодит жишээ баримтаар тайлбарлаарай

1. -----
2. -----
3. -----

**Даалгавар 3: Гуравдагч хөршийн бодлого гэж юу вэ? Төрийн гаргасан баримт бичигт заасан / эх сурвалж 1, 2,3 -ийг / заалтыг уншаад доорхи асуултуудын дагуу задлан шинжлээрэй**

**Эх сурвалж 1: Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал"-аас**

Хоёр. Улс төрийн гадаад харилцааны бодлого: 14.2.АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

Гурав. Эдийн засгийн гадаад харилцааны бодлого: 19.Эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхдээ эрх тэгш, харилцан ашигтай байх зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг чанд мөрдөнө. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтыг үндэс болгон эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хараат байдалд орохоос сэрэмжилнэ.

**Эх сурвалж 2: Монгол Улсын Үндсэн хуульд**

"Монгол улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна. Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй" гэж заасан

**Эх сурвалж 3: Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд**

3.1. "Үндэсний аюулгүй байдал" гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ.

3.2. "Үндэсний язгуур ашиг сонирхол"-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

**Гадаад бодлогын үзэл баримтлалд**

"Монгол улс нээлттэй, эвсэлд үл нэгдэх, олон тулгуурт гадаад бодлого явуулна" гэж заасан

Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/annex/?lawid=6163>

**Асуултууд:**


1. Монгол улсын гадаад бодлогын талаар төрөөс гаргасан баримт бичгүүдийг нэрлэн жагсааж бичээрэй вэ ?
2. "Монгол улсын гадаад бодлогын баримт бичгүүдийн заалтууд гуравдагч хөршийн бодлоготой ямар холбоотой байгааг тодорхойлно уу.
3. Үндэсний аюулгүй байдал, Үндэсний язгуур ашиг сонирхолын ялгааг тодруулна уу?
4. Монгол улс яагаад "гуравдагч хөрш"-ийн бодлогыг гадаад харилцаандаа баримтлах болсон бэ?
5. Монгол улсын гадаад харилцааны "гуравдагч хөрш"-ийн бодлогын зорилго, ач холбогдлыг хэрхэн тодорхойлох вэ?

**Даалгавар 4: Дараах улс орнуудтай Монгол улс стратегийн ямар түншлэлийн харилцаатай вэ? Цэгийн оронд нөхөж бичээд газрын зурагт цэгэн зураасаар холбож тэмдэглээрэй**

Энэтхэг  
/...../

ОХУ  
/...../

Япон  
/...../



АНУ  
/...../

БНХАУ  
/...../

Канад  
/...../

1. Монгол улс гуравдагч хөрштэйгээ хэзээнээс дипломат харилцаа тогтоож ирснийг нөхөж гүйцээнэ үү

A	Монгол улс ба Турк улсын харилцаа	1	
B	Монгол улс ба БНСУ-ын харилцаа	2	
C	Монгол улс ба Япон улсын харилцаа	3	

A	Монгол улс ба АНУ-ын харилцаа	1	
B	Монгол улс ба Япон улсын харилцаа	2	
C	Монгол улс ба БНСУ-ын харилцаа	3	

2. Монгол улс “Мянганы сорилт”-ын сан хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж ирсэн. Энэ нь аль улсын тусламж дэмжлэг вэ?

3. Дээрхи улс орнуудтай соёл, хүмүүнлэгийн чиглэлээр хэрхэн хамтарч ажиллаж байна вэ? Тодорхой жишээ татаж тайлбарлаарай

**Даалгавар 5 : Мэдээлэлд тулгуурлан зөөлөн хүчний бодлогын агуулга, чиглэлийг тодорхойлж, цаашид хэрхэн хэрэгжүүлэх арга замын талаар өөрийн байр сууриа илэрхийлж эсээ бичээрэй**



"Хот мандал-нууц тарнийн сүм" гэрэл зургийн үзэсгэлэнгийн нээлт, Софи хот, 2020.10.20

Олон улсын нэр хүндтэй үзэсгэлэн яармаг, урлаг, соёлын арга хэмжээнд Монгол Улсын оролцоог хангаж ажиллав. Энэ хүрээнд Швейцарын Цюрих хотод зохион байгуулсан "ФЕСБО-2020", Туркийн Истанбул хотноо зохион байгуулсан "EMMIT", АНУ-ын Калифорни мужийн Лос Анжелес хотод зохион байгуулсан "TRAVEL AND ADVENTURE SHOW" зэрэг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд тус тус оролцов. Мөн Дэлхийн банк болон "Олон улсын худалдааны төв" ТББ-тай хамтран "Монголын өвийн өдөр" соёлын арга хэмжээг Дэлхийн банкны төв байранд, Тайландын Бангкок хотод олон улсын аялал жуулчлалын 2 дугаар кино форум, Лос Анжелес хотод зохион байгуулсан.

Эх сурвалж: Гадаад харилцааны яамны албан ёсны сайт

**1. Эсээгээ дараах асуултуудын дагуу өөрийн байр сууриа илэрхийлэн үндэслэл, нотолгоо дэвшүүлж, жишээ баримтаар баяжуулж, дүгнэлт гарган бичээрэй**

Үүнд:

1. Зөөлөн хүчний бодлого гэж юу вэ ? Дээрхи мэдээлэлд ямар чиглэлийн үйл ажиллагаа дурдагдсан бэ, үүний давуу тал, ач холбогдлыг дурьдана уу
2. Гуравдагч хөршийн ямар улс орнуудыг дурдсан бэ? Соёл хүмүүнлэгийн чиглэлээр хэрхэн хамтарч ажиллаж байна вэ? Жишээ баримт татаж тайлбарлана уу?
3. Монгол улсыг гадаадад сурталчлахдаа тэргүүн ээлжинд Түүх соёл, урлаг, аялал жуулчлал, үндэсний брэнд, спорт олон улсын арга хэмжээ гэж тодорхойлсон. Таны бодлоор аль чиглэлийн сурталчилгааг эн тэргүүнд хийх нь ач холбогдолтой вэ? Яагаад?

**2. Өөрийн бичсэн эсээгээ дараах үзүүлэлтээр үнэлж, дахин сайжруулаарай**

1	Мэдлэг	
2	Үндэслэл, нотолгоо	
3	Бие даан бүтээлч сэтгэх	
4	Хэл найруулга	

## Бататгах сорил

1. “АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой гуравдагч хөршийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх болно.” гэж Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд заажээ. Монгол улс яагаад “Гуравдагч хөрш”-ийн бодлогыг хэрэгжүүлэх болсон бэ?

- Монгол улс зөвхөн БНХАУ-ын хамааралд бус дээрх улсуудын нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.
- Монгол улс Азийн бүсийн хамааралд бус Америк, Европын нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.
- Монгол улс зөвхөн ОХУ-ын хамааралд бус дээрх улсуудын нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.
- Монгол улс зөвхөн хоёр хөршийн хамааралд бус тэдний нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.
- Монгол улс зөвхөн Буриад, Өвөр Монголын хамааралд бус тэдний нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.

2. Монгол улсын гадаад бодлогын голлох бүс нутаг, улс орныг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?

- Хойд Америк, ба Европын улс орнууд
- Төв Африкийн орнууд
- Төв Азийн улс орнууд буюу тусгаар улсуудын хамтын нөхөрлөл
- Зүүн хойд Азийн бүс нутаг \ОХУ, БНХАУ, Солонгос, Япон г.м\
- Зүүн өмнөд Азийн бүс нутаг

### ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Дэд сэдэв	Дасгал даалгаврыг гүйцэтгэсэн чадвар	R	A	G	Comments
Олон улсын харилцаа	<ul style="list-style-type: none"><li>Улс бус оролцогчдыг ангилж, явуулж буй үйл ажиллагааны онцлог, нийтлэг, ялгаатай талыг тайлбарлаж чадна</li><li>Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд хамтран ажиллаж буй улс орнуудын талаарх мэдээллийг төрөлжүүлэн тайлбарлаж чадна.</li><li>Монгол улстай хамтарч ажилладаг олон улсын байгууллагууд, тэдгээрийн хамтын үйл ажиллагаа, харилцааны чиглэл, оролцоог нь жишээ татан оновчтой тайлбарладаг болсон</li><li>“Зөөлөн хүч”-ний бодлого нь бусад улс орон, олон улсын хамтын нийгэмлэгийн дунд байр сууриа бэхжүүлэхэд чиглэдэг болохыг үнэлж чадна</li><li>Мэдээлэл, баримтад тулгуурлан өөрийн байр сууриа илэрхийлж эсээ бичиж, шалгуурын дагуу үнэлж сурсан</li></ul>				

R- Багшийн тусламж авна

A- Дахин давтаж, нэмэлт дасгал ажиллана.

G- Өөрөө сайн хийж чаддаг болсон



Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хийгээрэй.

I II III

Бүлэг сэдэв/ Анги		Д.д	Хэрхэн ажилласан, ямар үр дүнд хүрсэн тухай тэмдэглээрэй.
Хүний эрх	11-3-1а	1. А-Г, 2, 3	
	11-3-1б	1-а-г,	
Эхэлсэн хугацаа			
Дууссан хугацаа			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			
Эдийн засаг	11-4-1а	1А, 2.1-4, 3.А-Б, 4.1-2	
	11-4-1б	1,2,3, А-Б	
Эхэлсэн хугацаа			
Дууссан хугацаа			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			
Улс төр	11-5-1а	1.1-3, 2,5.1- 3, 6,7,	
	11-5-1б		
Эхэлсэн хугацаа			
Дууссан хугацаа			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			
Олон улсын харилцаа	11-6-1а	1-3,2-1,2-2	
	11-6-1б	1.1-3,2-1,2-2	
	11-6-1в		
Эхэлсэн хугацаа			
Дууссан хугацаа			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			

Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хийгээрэй.

Бүлэг сэдэв/ Анги	11	Д.д	Хэрхэн ажилласан, ямар үр дүнд хүрсэн тухай тэмдэглээрэй.
Хүний эрх	11-3-1a	4.1-5,	
	11-3-1б	2, 3, 4. А-Б	
Эхэлсэн хугацаа			
Дууссан хугацаа			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			
Эдийн засаг	11-4-1a	5, 6,	
	11-4-1б	2. а-г	
Эхэлсэн хугацаа			
Дууссан хугацаа			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			
Улс төр	11-5-1a	3. 1-5, 4.1-2,	
	11-5-1б	8.	
Эхэлсэн хугацаа			
Дууссан хугацаа			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			
Олон улсын харилцаа	11-6-1a	3.1-2,	
	11-6-1б	3.1-5, 4.1-3	
	11-6-1в		
Эхэлсэн хугацаа			
Дууссан хугацаа			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			

Бүлэг сэдэв/ Анги	11		Хэрхэн ажилласан, ямар үр дүнд хүрсэн тухай тэмдэглээрэй.
		Д.д	
Хүний эрх	11-3-1a	5,6	
	11-3-16	5.1-5, 6.	
Эхэлсэн хугацаа			
Дууссан хугацаа			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			
Эдийн засаг	11-4-1a	7. 1-5	
	11-4-16	3. А-Г, 4	
Эхэлсэн хугацаа			
Дууссан хугацаа			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			
Улс төр	11-5-1a		
	11-5-16	10. 1-4	
Эхэлсэн хугацаа			
Дууссан хугацаа			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			
Олон улсын харилцаа	11-6-1a	4. 1-3	
	11-6-16		
	11-6-1в	5,	
Эхэлсэн хугацаа			
Дууссан хугацаа			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			

**Суралцахуйн зураглалтай ажиллах заавар:**

I алхам:	Багшийн зөвлөсөн дасгал, даалгавруудаас эхлэн ажиллаарай.
II алхам:	Өөрийн хийж чаддаг болсон дасгал, даалгавруудыг тохирох түвшний өнгөөр будаарай.
III алхам:	Тухайн бүлгийн дасгал, даалгаврыг гүйцэтгэж эхэлсэн болон дуусгасан хугацааг заавал тэмдэглээрэй.
IV алхам:	Дасгал, даалгаврыг гүйцэтгэсний дараа өөрийгөө үнэлээрэй.
V алхам:	Багшаараа үнэлүүлж, өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулаарай.